

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2015 оны 11 дүгээр сарын 9 -ны өдрийн 406/2015 дүгээр
хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралт

ДААТГАЛЫН КОМПАНИД МӨРДӨГ ДӨХ “САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГА БЭЛТГЭХ АРГАЧЛАЛ”

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Даатгалын компани нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхэд энэ зааврыг мөрдөнө. Харин даатгалын мэргэжлийн оролцогч болох Хохирол үнэлэгч болон зуучлагч нь Сангийн сайдын 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 77 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөнө.

1.2. Даатгалын компани нь жилийн санхүүгийн тайланг “А” маягтаар, улирлын санхүүгийн тайланг “Б” маягтаар гаргана.

1.3. Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.

1.4. Санхүүгийн тайлан, тодруулгын хасагдах утгатай дүнг хасах тэмдэгтэйгээр харуулна.

1.5. Даатгалын компани нь тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна. Тухайн компанийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч зарим нэг тодруулгыг заавал тодруулахгүй байж болно.

1.6. Санхүүгийн тайлангийн зорилго нь хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад шаардагдах тухайн даатгалын компанийн санхүүгийн байдал (хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгө), санхүүгийн үр дүн (ашиг, алдагдал), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээ), өмчийн өөрчлөлтийн тухай мэдээллээр хангахад оршино.

1.7. Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг Даатгалын компанийн удирдлага хүлээнэ.

1.8. Даатгалын компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд:

1.8.1. **Нягтлан бодох бүртгэлийн бодлого.** Даатгалын компанийн удирдлага өөрийн бодит нөхцөлд ялангуяа компанийхаа санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнг үнэн зөвөөр илэрхийлэх бүртгэлийн бодлогыг мөрдөнө. Сонгосон бүртгэлийн бодлого нь СТОУС, Монгол улсын хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журам, заавар, аргачлалд нийцнэ. Даатгалын компани нь нягтлан бодох бүртгэлийн тодорхойлогдоогүй зүйлсийг Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авна.

1.8.2. **Үнэн зөв толилуулга.** Санхүүгийн тайланд даатгалын компанийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлнэ. Үнэн зөв толилуулгад дан ганц тоогоор илэрхийлэгдсэн мэдээлэл төдийгүй нэмэлт тайлбар, тодруулгыг багтаана.

1.8.3. **Тасралтгүй байх зарчим.** Даатгалын компанийн удирдлага санхүүгийн тайланг бэлтгэхдээ өөрийн компанийн үйл ажиллагааны тасралтгүй зарчмаар үргэлжлэх чадварт үнэлэлт өгнө. Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоогоогүй тохиолдолд удирдлага тасралтгүй байх зарчмыг үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. Мөн компанийн үйл ажиллагааг тасалдуулахад хүргэх үйл явдал, нөхцөл байдал үүссэн бол даатгалын компанийн удирдлага нэн даруй Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэнэ. Даатгалын компанийн удирдлага тасралтгүй байх зарчим хадгалагдаж буй эсэхийг үнэлэхдээ тайлагналын өдрөөс хойш арван хоёр сар буюу түүнээс дээш хугацааг хамарсан ирээдүйн талаарх боломжит бүх мэдээллийг ашиглана. Компани ашигтай ажиллаж байсан түүхтэй бөгөөд санхүүгийн нөөцийг байршуулахад бэлэн байгаа бол нэмэлт шинжилгээ хийлгүйгээр тасралтгүй байх зарчим биелэгдэж байна гэж үзэж болно.

1.8.4. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь.** Даатгалын компани мөнгөн гүйлгээний тайлангаас бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэнэ. Аккруэл суурь гэж мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн

эсэхээс үл хамааран орлогыг олсон үед болон зардлыг гарсан тухай бүрт нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

- 1.1.1. **Илэрхийллийн тогтвортой байдал.** Даатгалын компанийн үйл ажиллагаанд гарсан үлэмж хэмжээний өөрчлөлт болон СТОУС-д шаардсанаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн илэрхийлэл ба ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед өөрчлөхгүй. Хэрэв ийм өөрчлөлт хийхээр төлөвлөж буй бол үүнийг Санхүүгийн зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэнэ.
- 1.1.2. **Харьцуулах боломжтой байх зарчим.** Энэ заавар болон СТОУС-ын шаардлагаар компанийн санхүүгийн тайлангийн тоон мэдээллийг арга зүйн хувьд бүх тайлант хугацааны тоо мэдээтэй харьцуулж болохоор зохион байгуулна. Санхүүгийн тайланд зэрэгцүүлэх зорилгоор оруулж байгаа өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна. Тухайлбал, орлогын дэлгэрэнгүй тайланг 6 дугаар сарын 30-ны өдрөөр бэлтгэж байгаа тохиолдолд толилуулах дүн нь тайлант ба өмнөх хугацааны аль алиных нь хувьд оны эхнээс (1 дүгээр сарын 1-ний өдөр) 6 дугаар сарын 30-ны (тайлагналын өдөр) хоорондох хугацаагаар тасалбар болно.
- 1.1.3. **Цэвэр дүнгээр толилуулах.** Энэ заавар болон Санхүүгийн тайлагналын олон улсын холбогдох стандартаар цэвэр дүнг гаргахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд даатгалын компан хөрөнгө, өр төлбөр эсвэл орлого, зардлыг цэвэр дүнгээр гаргахгүй байх.
- 1.1.4. **Цаг хугацаандаа байх зарчим.** Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь багтаан бэлтгэж, толилуулах нь мэдээллийг хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх боломжтой хугацаанд багтаан шийдвэр гаргагчдад хүргэхийг хэлнэ. Даатгалын компанийн үйл ажиллагааны онцгой хүндрэлтэй байдал зэрэг нь санхүүгийн тайланг цаг хугацаанд нь тайлагнахгүй байх шалтгаан болохгүй.
- 1.2. Иж бүрэн санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
 - 1.2.1. Санхүүгийн байдлын тайлан;
 - 1.2.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан;
 - 1.2.3. Өмчийн өөрчлөлтийн тайлан;
 - 1.2.4. Мөнгөн гүйлгээний тайлан;
 - 1.2.5. Санхүүгийн тайлангийн тодруулга орно.
- 1.3. Даатгалын компани нь дараах мэдээллийг толилуулна. Үүнд:
 - 1.3.1. Даатгалын компанийн нэр, өмнөх тайлант үеийн эцсийн мэдээлэл дэх аливаа өөрчлөлт;
 - 1.3.2. Санхүүгийн тайлан нь тусдаа санхүүгийн тайлан болох тухай;
 - 1.3.3. Тайлант үеийн эцсийн өдөр, санхүүгийн тайлан эсхүл тодруулгын хамрах хугацаа;
 - 1.3.4. Толилуулгын валют;
 - 1.3.5. Иж бүрэн санхүүгийн тайлан гэж санхүүгийн тайлангийн тодруулгыг багтаасан тайланг хэлэх ба үүнийг жилээр толилуулна. Санхүүгийн тайлангийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.
 - 1.3.6. Жил, улирлын тайланг жилийн эхнээс өссөн дүнгээр гаргана.

ХОЁР. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

- 2.1. Санхүүгийн байдлыг тодорхой хугацаагаар буюу тайлагналын өдрөөр тасалбар болгон харуулдаг тайлан нь санхүүгийн байдлын тайлан юм.
- 2.2. Санхүүгийн байдлыг хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгөөр харуулна.
 - 2.2.1. Хөрөнгө гэдэг нь компанийн хяналтанд байгаа бөгөөд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсч, ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх нөөц юм.
 - 2.2.2. Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд бий болсон, эдийн засгийн өгөөжийг өөртөө агуулж буй нөөцийн гадагшлах урсгалаар төлөгдөхөөр хүлээгдэж буй компанийн бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг хэлнэ.
 - 2.2.3. Өөрийн хөрөнгө гэдэг нь компанийн хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсэг юм.

2.3. Компани санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө ба өр төлбөрийг шинж чанар, хөрвөх чадвараар жагсааж, толилуулна.

2.4. Хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд зохих үнэлгээгээр илэрхийлж, нийт дүнгээр толилуулна. Хөрөнгө ба өглөгийн дүнг суутган тооцсон, эсвэл ингэж тооцохыг СТОУС ба хууль тогтоомжоор зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд балансад тусгасан аливаа хөрөнгө, өр төлбөрийн дүнг нэгийг нь нөгөөгөөс нь хасч тооцохгүй.

2.5. Санхүүгийн байдлын тайланг СТ-1 загварын дагуу бэлтгэнэ. СТОУС-д нийцүүлэн бэлтгэх жилийн санхүүгийн тайланг зэрэгцүүлсэн байдлаар толилуулна. Өөрөөр хэлбэл тайлант хугацааны үзүүлэлтийг нэг баганаар, зэрэгцүүлэгдэх хугацааны үзүүлэлтийг өөр баганаар тайлагнана. СТ-1 хэлбэрээр тайлагнасан 12 дугаар сарын тайлан ба аудитын дүгнэлт санал бүхий жилийн эцсийн тайлангийн хооронд зөрүү гарсан бол энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, тайлбар гаргаж өгнө.

2.6. Санхүүгийн байдлын зүйлсийг тайлант жилийн эхнээс өссөн дүнгээр гаргах ба эхний үлдэгдэл нь тухайн тайлант санхүүгийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөрх үлдэгдэл байна.

2.7. Хөрөнгийн дараах зүйлсийг тусад нь толилуулна:

2.7.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө: үнэ цэнийн өөрчлөлтөөс өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, түргэн борлогдох чадвартай, богино хугацаат хөрөнгийг хэлнэ. Анх гаргасан хугацаанаас хойш 3 сараас дээш хугацаатай, ямар нэгэн нөхцлөөр хязгаарлагдсан мөнгөн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь бэлэн мөнгө, банкин дахь харилцах, хадгаламж, гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж зэрэг багтана. Үүнд: бэлэн мөнгө, замд яваа мөнгө, банкинд байршуулсан харилцах, хугацаагүй хадгаламж, банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд 3 сар хүртэл хадгаламж, хадгаламжийн сертификат, Монголбанк болон Засгийн газраас гаргасан богино хугацаат үнэт цаас эдгээр хөрөнгөнд хуримтлуулан тооцсон хүүг оруулна.

2.7.2. Үнэ цэнд гарах өөрчлөлтийн эрсдэл буюу үнэ цэнийн бууралтын эрсдэл тодорхойгүй тул Монголбанк болон Засгийн газраас бусад этгээдийн гаргасан үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг мөнгө ба мөнгөтэй адилтгах зүйл гэж үзэхгүй. Ийм төрлийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг 90 хоног (3 сар) -оос богино хугацаатай байсан ч хөрөнгө оруулалтаар бүртгэнэ.

2.7.3. Тодорхой зориулалтаар зарцуулалт нь хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө, барьцаалсан мөнгөн хөрөнгө, харилцагч банк төлбөрийн чадваргүй болох зэрэг шалтгаанаар гүйлгээ хийгдэх боломжгүй болсон харилцах данс, хугацаатай хадгаламж гэх мэт зарцуулалт нь хязгаарлагдсан, шууд төлбөр хийгдэх боломжгүй харилцах дансыг мөнгөн хөрөнгө гэж ангилахгүй. Харин тэдгээрийг хязгаарлалт, хугацаа зэргээс хамааран хөрөнгө оруулалт эсвэл авлага гэж ангилж болно.

2.7.4. Даатгалын авлага: Даатгалын бүтээгдэхүүн борлуулсан, үйлчилгээ үзүүлснээс үүссэн бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн нэхэмжлэх дүн юм. Үүнд: даатгалын хураамжийн авлага, буруутай этгээдээс авах авлага, давхар даатгагчаас авах авлага хамаарна.

2.7.5. Даатгалын хөрөнгөнд хойшлогдсон давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг, даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал зэрэг байна:

2.7.5.1. Давхар даатгалын зардлыг даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байгаа хэсгийг хойшлогдсон давхар даатгалын хураамжийг хэлнэ.

2.7.5.2. Нөхөн төлбөр олгоход зориулан байгуулсан нөөц сан (Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан болон Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан)-гаас тайлант хугацаанд олгохоор тооцоолсон нөхөн төлбөрийн давхар даатгагчийн хариуцах хэсгийг даатгалын нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг гэж хэлнэ.

- 2.7.5.3. Даатгалын гэрээг олж бэлтгэхтэй холбогдон даатгалын зуучлагч, төлөөлөгчид урьдчилж төлсөн шимтгэлийн зардал болон бусад шууд зардлыг даатгалын гэрээний хугацаатай уялдуулан тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөөгүй хэсгийг хэлнэ.
- 2.7.6. Хөрөнгө оруулалт: Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат, мөн тэдгээрт хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, Засгийн газрын өрийн хэрэгсэл, Төв банкны үнэт цаас, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Орон нутгийн гаргасан өрийн бичиг, Компанийн бонд, ХБ-ийн I ба II ангиллын хувьцаа, вексель, хөрөнгө оруулалтын сангийн үнэт цаас /нэгж эрх/, гадаадын үнэт цаас, холбогдох этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгө барьцаасан богино хугацаат зээл, санхүүгийн түрээс, деривативт олон төрлийн гэрээ, хэлцэл, санхүүгийн хэрэгсэл бүхий гадаад валют, үнэт металлыг худалдах буюу худалдан авах форвард, своп, опшин, фьючерс хамруулна.
- 2.7.7. Бусад санхүүгийн хөрөнгө: Даатгалын үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангаж буй хөрөнгүүд болох бусад тооцооны авлага, салбар хоорондын тооцоо, бусад санхүүгийн хөрөнгийг хамруулна.
- 2.7.8. Бусад санхүүгийн бус хөрөнгө: Даатгалын үйл ажиллагааны хувьд туслах чанарын бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй хөрөнгүүд болох тайлант хугацааны татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт бараа материал, урьдчилж төлсөн зардал/тооцоо, санхүүгийн бус хөрөнгийн хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгийг хамруулна. Өмчлөх бусад хөрөнгөнд зээлдэгчдээс зээлийн төлбөрт авсан болон нөхөн төлбөрийн тооцоонд авсан, цаашид худалдан борлуулах зориулалттай хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө багтана.
- 2.7.9. Үндсэн хөрөнгө: Даатгалын ажил, үйлчилгээ үзүүлэх, бусдад түрээслүүлэх эсвэл захиргааны зориулалтаар ашиглах үүднээс даатгалын компани эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдаж буй газрын сайжруулалт, барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, санхүүгийн түрээсийн хөрөнгө, дуусаагүй барилга зэргийг хамарна.
- 2.7.10. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө: Хөрөнгийн үнийг өсгөх, түрээсийн орлого олох зорилгоор эзэмшиж, өмчилж буй хөрөнгийг хэлэх бөгөөд компанийн үйл ажиллагаа, удирдлагын зорилгоор ашиглагдаагүй үл хөдлөх хөрөнгийг харуулна. Компани ашгийн бус зорилгоор буюу холбогдох зардлаа нөхөхийн тулд хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг эзэмшиж, өмчилж болно.
- 2.7.11. Биет бус хөрөнгө: Нэгээс дээш жилийн хугацаанд ашиглах компанийн үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглаж буй биет шинж чанаргүй тодорхойлж болохуйц, мөнгөөр илэрхийлэгдээгүй, материаллаг дүнтэй зохиогчийн эрх, программ хангамж, патент, барааны тэмдэг, тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрх, бусад биет бус хөрөнгө зэрэг хамаарна.
- 2.8. Өр төлбөрийн дараах зүйлсийг тусад нь толилууулна:
- 2.8.1. Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой үүссэн өглөг буюу даатгалын хураамжийн буцаалтын өглөг, нөхөн төлбөрийн өглөг, даатгалын гэрээний шимтгэлийн өглөг, давхар даатгагчид өгөх өглөг хамаарна.
- 2.8.2. Бусад санхүүгийн өр төлбөр: Даатгалын компанийн үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж буй өр төлбөр ба үүнд зээлийн өглөг, өрийн бичиг, санхүүгийн түрээсийн өр төлбөр, ногдол ашгийн өглөг, деривативын өр төлбөр, бусад санхүүгийн өр төлбөр, салбар хоорондын тооцооны өглөг хамрагдана.
- 2.8.3. Бусад санхүүгийн бус өр төлбөр: Даатгалын компанийн үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй өр төлбөр ба үүнд: цалингийн өглөг, НДШ-ийн өглөг, бусад татварын өглөг, ААНОАТ-ын өглөг,

- хойшлогдсон татварын өглөг, урьдчилж орсон орлого, нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр, хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсийн өр төлбөр, мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион, тэтгэврийн сангийн өр төлбөр, санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого, бусад санхүүгийн бус өр төлбөр зэрэг хамрагдана.
- 2.8.4. Хоёрдогч өглөг: Санхүүгийн эх үүсвэр болгож хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө бөгөөд хувьцаагаар солих талаар холбогдох гэрээнд заасан өрийн бичгийг хэлнэ. Энэ нь өр төлбөрийн шинжийг хадгалсан хэвээр байдаг тул үүнийг санхүүгийн тайланд өр төлбөрөөр толилуулна.
- 2.8.5. Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр): НББОУС 32-д заасны дагуу өр төлбөр гэж үзэх давуу эрхийн хувьцааг өр төлбөрөөр толилуулна.
- 2.8.6. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц: Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН) нь даатгалын гэрээний хугацаанаас хамааруулан орлогыг хувь тэнцүүлэн хуваарилах ба тайлант хугацаанд орлогод хүлээн зөвшөөрөгдөөгүй хураамжийн орлого байна.
- 2.8.7. Нөхөн төлбөрийн нөөц сан нь Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС), Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС)-гуудаас бүрдэнэ.
- 2.8.7.1. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС) гэдэгт тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно.
- 2.8.7.2. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС) гэдэгт даатгалын тохиолдол болсон тухай даатгагч мэдсэн болон төлөөгүй байгаа нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно.
- 2.8.7.3. Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС) гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно.
- 2.9. Өөрийн хөрөнгийн дараах зүйлсийг тусад нь толилуулна:
- 2.9.1. Эздийн өмч буюу өөрийн хөрөнгө нь компанийн бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгө юм.
- 2.9.2. Хувьцаа: Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгахад түүний эд хөрөнгөөс тодорхой хэсгийг өмчлөх эрхийг гэрчилж буй үнэт цаас юм. Хувьцаа нь энгийн болон давуу эрхийн хувьцаа гэсэн хоёр төрөлтэй байна.
- 2.9.3. Хувь нийлүүлсэн хөрөнгө: Даатгалын компаниас гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны (НББОУС 32-ын дагуу өмчийн шалгуурыг хангасан) нэрлэсэн үнийн дүнг хэлнэ.
- 2.9.4. Нэмж төлөгдсөн капитал гэж хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн зөрүүг хэлнэ.
- 2.9.5. Халаасны хувьцаа: Даатгалын компанийн гаргасан хувьцаанаасаа эргүүлэн худалдан авсан хувьцааг хэлнэ.
- 2.9.6. Хуримтлагдсан ашиг: Үйл ажиллагаа эхэлсэн үеэс хуримтлагдаж, ногдол ашиг хуваарилах буюу сан байгуулсны дараа үлдэж буй цэвэр ашиг юм.
- 2.9.7. Бусад өөрийн хөрөнгө: Тусгай зориулалтын сан, тогтвортой байдлын сан, хувьцаанд суурилсан төлбөр, хувьцаа эзэмшигчдээс оруулсан бусад хөрөнгө, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

ГУРАВ. ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

3.1. Орлогын дэлгэрэнгүй тайлан нь даатгалын компанийн тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүнг хэмждэг тайлан юм. Орлогын дэлгэрэнгүй тайланд орлого, зардлыг аккруэл сууриар бүртгэж, толилуулна.

3.2. Үйл ажиллагааны үр дүнг хэмжихтэй холбогдох элементүүд нь орлого, зардал, олз, гарз болно.

3.2.1. Орлого гэдэг нь тайлант хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсвэл хувь нийлүүлэгчдээс оруулсан хөрөнгөтэй

холбоогүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм. Орлогын дүнг найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд орлогын тайланд орлого болон олзыг хүлээн зөвшөөрнө. Найдвартай хэмжих боломжгүй бол бүртгэхгүй.

3.2.2. Зардал гэдэг нь хувьцаа эзэмшигчдэд олгосон хуваарилалттай холбоогүй, өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгийн хорогдол буюу гадагшлах урсгал эсвэл өр төлбөр үүсэх зэрэг хэлбэрээр тайлант хугацаанд бий болсон эдийн засгийн өгөөжийн бууралт юм. Зардлын дүнг найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд орлогын тайланд зардал болон гарзыг хүлээн зөвшөөрнө. Найдвартай хэмжих боломжгүй бол бүртгэхгүй.

3.3. Зардлыг холбогдох орлоготой уялдуулан орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба үүнийг орлого, зардлыг уялдуулах зарчим гэнэ. Ингэж орлого, зардлыг уялдуулснаар аливаа зүйл эсвэл ажил гүйлгээний орлого, зардлыг хамтад нь тайлагнаж, үр дүнг нь тодорхойлон гаргах ач холбогдолтой. Гэхдээ СТОУС-ын дагуу уялдуулах зарчмыг мөрдөхдөө хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтонд нийцэхгүй зүйлсийг балансанд хүлээн зөвшөөрч, харуулахгүй.

3.4. Орлогын дэлгэрэнгүй тайланг СТ-2 загварын дагуу бэлтгэнэ. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийг дүнгээр үзүүлэх ба орлого, зардлын бус шинжтэй зүйлийг орлогын тайланд тусгахгүй. Өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна. Тухайлбал, орлогын дэлгэрэнгүй тайланг 6 дугаар сарын 30-аар бэлтгэж байгаа тохиолдолд толилуулах дүн нь тайлант ба өмнөх хугацааны аль алиных нь хувьд оны эхнээс (1 дүгээр сарын 1-ний өдөр) 6 дугаар сарын 30-ны (тайлагналын өдөр) хоорондох хугацаагаар тасалбар болно.

3.5. Даатгалын компани орлого, зардлыг үндсэн төрлөөр ангилан орлогын дэлгэрэнгүй тайлан бэлтгэж, тодруулна.

3.6. СТОУС бусад стандартуудын шаардлагыг хангах үүднээс орлогын тайлангийн доор дурдсан орлого ба зардлын үзүүлэлтийг эдгээр ангиллаар хязгаарлахгүйгээр оруулна.

3.6.1. Даатгалын компанийн үйл ажиллагаанаас буй болох орлогын үндсэн төрөлд даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг орно.

3.6.1.1. Даатгалын хураамжийн орлого нь даатгалын компанийн тайлант хугацаанд хийсэн даатгалын гэрээний дагуу даатгуулагчаас төлсөн нийт хураамжийн орлогын дүн байна.

3.6.1.2. Давхар даатгалын шимтгэлийн орлогод давхар даатгагчаас давхар даатгалын борлуулалтын шимтгэл хэлбэрээр даатгагчид буцаан төлсөн төлбөрийн тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөгдөх хэсэг хамаарна. Давхар даатгалын шимтгэлийн орлого орж ирсэн үед нь урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч давхар даатгалын хураамжийн хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

3.6.1.3. Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр гэдэгт даатгалын тохиолдол болсон нөхцөлд гэрээнд заасны дагуу давхар даатгагчаас даатгагчид төлсөн болон төлөхөөр тооцсон нөхөн төлбөр хамаарна.

3.6.1.4. Даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлсэн болон төлөхөөр тохирсон дүнгээр буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөрийн орлого болгоно.

3.6.1.5. Нөөц сангийн хөрөнгө, дүрмийн сангийн хөрөнгө болон тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан сул чөлөөтэй хөрөнгийг аривжуулах зорилгоор байршуулснаар олох орлого, олзыг хөрөнгө оруулалтын орлого гэж ойлгоно.

3.6.2. Даатгалын компанийн үйл ажиллагаанаас буй болох зардлын үндсэн төрөлд давхар даатгалын хураамж, даатгалын хураамжийн буцаалт, даатгалын гэрээний зардал зэрэг орно.

3.6.2.1. Даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгаж төлж байгаа болон төлөхөөр тооцсон төлбөр давхар даатгалын хураамжид хамаарна.

- 3.6.2.2. Даатгалын хураамжийн буцаалт нь даатгалын гэрээ цуцлагдахад гэрээний үлдэх хугацаанд ногдох хураамжаас гэрээнд заасны дагуу даатгуулагчид өгөх даатгалын хураамж юм.
- 3.6.2.3. Даатгалын гэрээний зардалд даатгалын төлөөлөгчийн шимтгэл, даатгалын зуучлагчийн төлбөрийн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөгдөх хэсэг хамаарна. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл, даатгалын зуучлагчийн төлбөрийг төлсөн үед даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрч, холбогдох хураамжийг орлогоор хүлээн зөвшөөрсөн хувь хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрнө.
- 3.6.3. Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагааны ашиг болон алдагдалд дараах өөрчлөлтүүд нь нөлөөлнө. Үүнд: орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт, хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлт, нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт, нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт, УБХНСангийн өөрчлөлт зэрэг байна. Эдгээр өөрчлөлтүүдийн үлдэгдэл нь эерэг (+) утгатай байвал үндсэн үйл ажиллагааны ашгийг нэмэгдүүлэх ба сөрөг (-) утгатай байвал үндсэн үйл ажиллагааны ашгийг бууруулна.
- 3.6.3.1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт: Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг тодорхойлно.
- 3.6.3.2. Хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлт: Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг тодорхойлно.
- 3.6.3.3. Орлогод тооцсон хураамжийн орлого: Даатгалын хураамжийн орлогын цэвэр дүнгээс давхар даатгалын хураамж, орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт болон хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг хасч орлогод тооцсон хураамжийн орлогыг тодорхойлно.
- 3.6.3.4. Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт: Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан, Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангуудын тайлант үеийн өөрчлөлт хамаарна. Дээрхи нөөц сангуудын тайлант үеийн үлдэгдлээс тайлант үеийн эхний үлдэгдлийг хасч нөөц сангуудын өөрчлөлтийг тодорхойлно.
- 3.6.3.5. Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт: Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн тайлант үеийн өөрчлөлт хамаарна. Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн тайлант үеийн үлдэгдлээс тайлант үеийн эхний үлдэгдлийг хасч энэхүү өөрчлөлтийг тодорхойлно.
- 3.6.3.6. УБХНСангийн өөрчлөлт: Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн тайлант үеийн үлдэгдлээс тайлант үеийн эхний үлдэгдлийг хасч өөрчлөлтийг тодорхойлно.
- 3.6.4. Даатгалын үндсэн үйл ажиллагаанаас үүсэх ашиг (алдагдал) нь даатгалын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон орлого мөн зардлын зөрүүгээр тодорхойлогдоно.
- 3.6.5. Бусад орлого: Даатгалын үйл ажиллагаанаас орох орлогоос бусад бүх орлого хамрагдана. Үүнд: түрээсийн орлого, эрхийн шимтгэлийн орлого түүний хүү, бусад орлого зэрэг байна. Үйл ажиллагааны бус бусад орлогод гадаад валютын ханшийн зөрүүний олз, биет ба биет бус хөрөнгө борлуулсны болон данснаас хассаны олз, үндсэн хөрөнгийн түрээсийн орлого, торгуулийн олз, ногдол ашгийн орлого, тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөлт, бусад орлого, олзыг хамарна.
- 3.6.6. Бусад зардал: Даатгалын үйл ажиллагааны зардлын үндсэн төрөлд хамаарахгүй даатгалын үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжих нэгжийн зардлууд байна. Уг зардлыг ерөнхий ба удирдлагын, борлуулалт

маркетингийн, санхүүгийн, үйл ажиллагааны бусад зардал болон үйл ажиллагааны бус зардал гэсэн бүлэгтэй байна.

- 3.6.6.1. Ерөнхий ба удирдлагын зардал, Борлуулалт маркетингийн зардал: Ажилтнуудтай холбоотой цалин, шагнал урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал байна. Татвар төлбөр хураамжийн зардалд хуулийн дагуу төлж буй бүх төрлийн татвар, хураамж, төлбөр, даатгалын зохицуулалт үйлчилгээний зардал; томилолт нь дотоод, гадаад томилолт; бичиг хэргийн зардалд хэвлэх, олшруулах төхөөрөмжийн хор, даатгалын гэрээт баталгаа, даатгалын маягт, санхүүгийн маягт, цаас, бичгийн хэрэгсэлийн зардал; шуудан холбооны зардал хэсэгт байгууллагад ашиглагдаж буй интернет, суурин болон үүрэн утасны зардал мөн бусад шуудан холбооны зардлын шинжтэй зардал; мэргэжлийн үйлчилгээний зардалд аудитын үйлчилгээ, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ, авлага болон буруутай этгээдээс авлага барагдуулахтай холбоотой зардал, бусад бусдаар гүйцэтгүүлсэн зардал; гадаад, дотоодын сургалтын зардал; мэргэжлийн ном, сонин сэтгүүлийн зардал; албан ба сайн дурын даатгалын зардал; цахилгаан дулаан, цэвэр бохир ус, бусад ажлын байрны ашиглалттай холбоотой ашиглалтын зардал; газрын сайжруулалттай холбоотой урсгал зардал, барилга байгууламжийн урсгал засвар /капиталжихгүй/, машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлийн засвар үйлчилгээ, хэвлэх, хувилах төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэлийн засвар үйлчилгээний зардал, санхүүгийн түрээсийн зардал зэрэг засвар үйлчилгээтэй холбогдох гарах зардал; элэгдэл хорогдолын зардал; түрээсийн зардал; харуул хамгаалалтын зардал; цэвэрлэгээ үйлчилгээний зардал, тээврийн зардал; шатахууны зардал; хүлээн авалт баяр ёслол, биеийн тамир, соёлын арга хэмжээний зардал, бэлэг дурсгалын зардал; зар сурталчилгааны зардал гэх зардлууд хамаарна.
- 3.6.6.2. Санхүүгийн зардал: хүүгийн зардал, санхүүгийн түрээсийн хүүгийн зардал, санхүүгийн байгууллагын шимтгэл хураамжийн зардал.
- 3.6.6.3. Үйл ажиллагааны бусад зардал.
- 3.6.6.4. Үйл ажиллагааны бус зардал: Үндсэн бус үйл ажиллагаатай холбогдон гарсан зардал байна. Үүнд: хандив тусламжийн зардал; СЗХ-ны “Даатгалын компанийн активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу активт байгуулсан эрсдлийн сангийн зардлууд; болзошгүй өр төлбөрөөс үүссэн гарз, бондын эргэлтээс гаргалтын гарз; үйл ажиллагааны бус бусад зардлууд хамаарна.
- 3.6.7. Орлогын татварын зардал: тайлант хугацааны татвар ногдуулах орлогыг тодорхойлж, түүнд ногдуулж тооцсон татварын зардал (хөнгөлөлт)-ыг энэ хэсэгт тусгана.
- 3.6.8. Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал: СТОУС 5-ын дагуу зогсоосон үйл ажиллагаа гэж тодорхойлсон үйл ажиллагааны үр дүнд үүссэн орлого, зардлыг энэ хэсэгт тусгана.
- 3.6.9. Бусад дэлгэрэнгүй орлого: тайлант хугацааны цэвэр ашигт хамаарахгүй боловч эзэмшигчийн бус ажил гүйлгээгээр үүссэн хэрэгжээгүй орлого, зардал буюу үнэлгээний санд гарсан хэрэгжээгүй орлого, зардлыг харуулна. Татвар ногдуулах бүх орлого, зардалд хойшлогдсон татварыг хуримтлуулан бүртгэнэ.
- 3.6.10. Нийт дэлгэрэнгүй орлого: тайлант хугацаанд эзэмшигчийн бус ажил гүйлгээгээр цэвэр хөрөнгөнд гарсан нийт өсөлт, бууралтыг дараах хоёр үзүүлэлтээр төлөөлж харуулна: цэвэр ашиг, алдагдлын дүн (орлогын тайланд тодорхойлогдоно) ба бусад дэлгэрэнгүй орлого.

ДӨРӨВ. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

4.1. Өмчийн өөрчлөлтийн тайлан нь даатгалын компанийн цэвэр хөрөнгө буюу эзэмшигчийн өмчийн хөдөлгөөнийг харуулдаг тайлан юм.

- 4.2. Өмчийн өөрчлөлтийн тайланд дараах зүйлсийг толилуулна:
 - 4.2.1. тайлант хугацааны цэвэр ашиг, алдагдал;
 - 4.2.2. хувьцаат капиталтай холбогдуулан шууд бүртгэсэн орлого, зардал, олз, гарз, холбогдох дансдын дүн;
 - 4.2.3. нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын хуримтлагдсан нөлөөлөл;
 - 4.2.4. эзэмшигчидтэй хийсэн өмчийн ажил гүйлгээ, тэдгээрийг эзэмшигчдэд хуваарилсан байдал;
 - 4.2.5. тайлант хугацааны эхэнд болон санхүүгийн тайлагналын өдрөөрх хуримтлагдсан ашиг, алдагдлын үлдэгдэл, мөн хугацаанд гарсан өөрчлөлт;
 - 4.2.6. тайлант хугацааны эх болон эцэс дэх эзэмшигчийн өмчийн ангилал тус бүрийн дансны үнэ, нэмж төлөгдсөн капитал, сангуудын тохируулга, өөрчлөлт.
- 4.3. Өмчийн өөрчлөлтийн тайланг СТ-3 загвараар бэлтгэнэ.
- 4.4. Өөрийн хөрөнгийн тайлант үеийн эхний үлдэгдлийг өмчийн ангилал бүрийн хувьд өмнөх үеийн эцсийн үлдэгдлээр тусгана.
- 4.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, үндсэн алдааны залруулгыг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулах замаар тохируулж, залруулагдсан эхний үлдэгдлийг тодорхойлно.
- 4.6. Дараах зүйлсийн хөдөлгөөнийг тусад нь харуулна:
 - 4.6.1. Эздийн өмч буюу өөрийн хөрөнгө нь компанийн бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгийг;
 - 4.6.2. Нэмж төлөгдсөн капитал: хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн зөрүүг;
 - 4.6.3. Тогтвортой байдлын сан: компани үндсэн үйл ажиллагаанаас ирээдүйд үүсч болзошгүй алдагдалыг санхүүжүүлэх зорилгоор хувь нийлүүлэгчдийн шийдвэрээр байгуулсан санг ойлгоно.
 - 4.6.4. Дахин үнэлгээний нэмэгдэл: Үндсэн хөрөнгө болон борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт, бууралтыг өмчийн өөрчлөлтийн энэ хэсэгт тусгана.
 - 4.6.5. Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц: дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтээс, бүртгэлийн валютыг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн валютын хөрвүүлэлтийн зөрүүг тодруулна.
 - 4.6.6. Хувь нийлүүлсэн хөрөнгө: даатгалын компаниас гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг;
 - 4.6.7. Халаасны хувьцаа гэж даатгалын компанийн гаргасан хувьцаанаасаа эргүүлэн худалдан авсан хувьцааг;
 - 4.6.8. Хуримтлагдсан ашиг: үйл ажиллагаа эхэлсэн үеэс хуримтлагдаж, ногдол ашиг хуваарилах буюу сан байгуулсны дараа үлдэж буй цэвэр ашгийг;
 - 4.6.9. Бусад өөрийн хөрөнгө: тусгай зориулалтын сан, хувьцаанд суурилсан төлбөр, хувьцаа эзэмшигчдээс оруулсан бусад хөрөнгө, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.
- 4.7. Нийт өмчийн эхний үлдэгдэл дээр нийт нэмэгдсэн өөрчлөлтийн дүнг нэмж, нийт хасагдсан өөрчлөлтийн дүнгээр бууруулж, өмчийн эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

ТАВ. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- 5.1. Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд үзүүлнэ. Мөнгөн гүйлгээний тайлан нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг бий болгох тухайн байгууллагын чадвар, эдгээр мөнгөн гүйлгээг ашиглах хэрэгцээг үнэлэх үндэс болдог.
- 5.2. Мөнгөн гүйлгээний тайланг СТ-4 загвараар бэлтгэнэ. Зэрэгцүүлэх зорилгоор оруулж байгаа өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна.
- 5.3. Мөнгөн гүйлгээний тайланг шууд аргаар бэлтгэнэ.
- 5.4. Мөнгөн гүйлгээний тайлан нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - 5.4.1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;
 - 5.4.2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;

5.4.3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;

5.4.4. Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт).

5.5. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн даатгалын компанийн хувьд даатгуулагчид учирсан эрсдлийг нөхөн төлөх, бусад өр төлбөр төлөх, үйл ажиллагааны чадавхийг тогтоон барих, ногдол ашиг төлөх ба гадны санхүүжилтийн эх үүсвэрийн тусламжгүйгээр шинэ хөрөнгө оруулалт хийхэд хангалттай хүрэлцэх мөнгө бий эсэхийг илэрхийлдэг гол үзүүлэлт юм.

5.5.1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогод:

5.5.1.1. Даатгалын хураамжийн орлого;

5.5.1.2. Давхар даатгалын хариуцсан нөхөн төлбөр;

5.5.1.3. Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр;

5.5.1.4. Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого;

5.5.1.5. Буцаан авсан албан татвар;

5.5.1.6. Улсаас авсан татаас, санхүүжилт;

5.5.1.7. Бусад мөнгөн орлого (тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөлт гм) орно.

5.5.2. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:

5.5.2.1. Ажиллагчдад төлсөн;

5.5.2.2. Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн;

5.5.2.3. Бараа материал худалдан авахад төлсөн;

5.5.2.4. Ашиглалтын зардалд төлсөн;

5.5.2.5. Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж;

5.5.2.6. Нөхөн төлбөрт төлсөн;

5.5.2.7. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл;

5.5.2.8. Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр;

5.5.2.9. Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр;

5.5.2.10. Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн;

5.5.2.11. Хүүний төлбөрт төлсөн;

5.5.2.12. Татварын байгууллагад төлсөн;

5.5.2.13. Бусад мөнгөн зарлага.

5.5.3. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно.

5.6. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь ирээдүйд олох орлого ба мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт хөрөнгө, нөөц бий болгоход зарцуулсан мөнгийг илэрхийлдэг. Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ нь урт хугацаанд ашиглагдах хөрөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгөнд ороогүй бусад хөрөнгө оруулалтыг олж эзэмших болон худалдах үйл ажиллагааг хамарна.

5.6.1. Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогод:

5.6.1.1. Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө (тухайлбал ХОЗҮХХ, бусад санхүүгийн хөрөнгө) борлуулснаас;

5.6.1.2. Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт борлуулснаас;

5.6.1.3. Бусад талуудад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлтөөс; (санхүүгийн байгууллагын хувьд олгосон зээл, мөнгөн урьдчилгаа нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд хамаарна);

5.6.1.4. Мөнгөөр хүлээн авсан хүү;

5.6.1.5. Мөнгөөр хүлээн авсан ногдол ашиг;

5.6.1.6. Бусад мөнгөн орлого.

5.6.2. Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагад:

5.6.2.1. Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө;

5.6.2.2. Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө;

5.6.2.3. Бусад талуудад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа;

5.6.2.4. Бусад мөнгөн зарлага орно.

5.6.3. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.

5.7. **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** нь санхүүжилтийн бусад эх үүсвэр, орж ирэх хөрөнгө оруулалттай холбоотойгоор өр төлбөр ба өөрийн хөрөнгө өөрчлөгдөх үйл ажиллагааг хамарна.

5.7.1. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогод:

5.7.1.1. Банкнаас авсан урт болон богино хугацааны зээл, бүх төрлийн өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө;

5.7.1.2. Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө;

5.7.1.3. Бусад мөнгөн орлого.

5.7.2. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:

5.7.2.1. Зээл, өрийн бичгийн төлбөрт төлсөн мөнгө, урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт;

5.7.2.2. Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн;

5.7.2.3. Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн;

5.7.2.4. Мөнгөөр төлсөн ногдол ашиг;

5.7.2.5. Бусад мөнгөн зарлага.

5.7.3. Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.

5.8. **Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт, бууралтыг** үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр тодорхойлно. Мөн үүнд мөнгөн хөрөнгөтэй холбогдуулан үүссэн ханшийн зөрүүний нөлөөллийг багтаах ба уг нөлөөллийг тооцоолохдоо мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг валютын албан ханшаар дахин илэрхийлж, өмнөх ханшаар илэрхийлж байсан дүнгээс хасна.

5.9. Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч тодорхойлсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайланд тодорхойлогдсон "Бүх цэвэр мөнгөн гүйлгээ"-ний дүнтэй тэнцүү байна.

5.10. Мөнгөн гүйлгээг нэмэгдүүлэх ба хорогдуулахад нөлөөлдөггүй ажил гүйлгээнд хувьцаа гаргаж орлогод авсан үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгө ба санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээ, хувьцаагаар олгох ногдол ашиг гэх мэт орно.

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

6.1. Даатгалын компанийн санхүүгийн тайлангийн тодруулгад доорх зүйлсийг хамруулна:

6.1.1. Санхүүгийн тайланг бэлтгэх тулгуур үзэл баримтлал, ажил гүйлгээ ба үйл явдлыг бүртгэхээр сонгож авсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх тайлбарыг агуулсан байх;

6.1.2. Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэх зэрэг санхүүгийн тайлангуудад тусгагдаагүй боловч СТОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулсан байх;

6.1.3. Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлантай холбоотойгоор хийсэн нарийвчилсан шинжилгээ, нэмэлт тайлбар, болзошгүй үүрэг гэх мэт нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгана.

6.2. Санхүүгийн тайлангийн тодруулгад санхүүгийн тайлангийн зүйл тус бүрийн мэдээллийг тайлангийн дэс дарааллын дагуу толилуулна. Толилуулж, тодруулж буй дүнг зэрэгцүүлэх сууриар бэлтгэнэ (өөрөөр хэлбэл, тайлант хугацааны дүнг өмнөх хугацааны дүнтэй зэрэгцүүлнэ).

Тайлан бэлтгэх үндэслэл

6.3. Даатгалын компанийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, компанийн нэр, санхүүгийн тайлангийн дуусгавар болсон огноо, санхүүгийн тайлангийн хамарсан хугацаа, компанийн бүтэц, зохион байгуулалтанд гарсан гол өөрчлөлт, санхүүгийн тайлан СТОУС-д нийцсэн тухай тайлбар, нягтлан бодох бүртгэлийн ашиглаж буй суурь, ерөнхий бодлогын товч тайлбар зэргийг товч тодорхойлж, харуулна.

6.4. Шинээр гарсан бөгөөд тухайн тайлант жилийн эхнээс мөрдөж эхлэх СТОУС, дараагийн тайлант үеэс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх СТОУС, тайлбарыг тус тус

анхааран үзэж, мөрдлөг болгох ба шинэ стандарт, тайлбарыг мөрдсөн жилийн ба түүнээс хойшхи жилүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөллийг үнэлнэ. Энэ мэдээллийг СТОУС-д нийцүүлсэн тухай мэдэгдэл эсвэл санхүүгийн тайлангийн тодруулгын холбогдох хэсэгт дурдана.

6.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахдаа санхүүгийн тайланд тусгасан үзүүлэлтүүдийг бүртгэх аргуудыг тайлбарлан үзүүлнэ. Зарим зүйлсийг хүснэгтээр илэрхийлж болно. Үүнээс гадна нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахдаа дараах зүйлсийн тухай дурдаж болно:

6.5.1. Санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах арга ажиллагаа;

6.5.2. Компанид мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэл хөтлөх маягт, аргачлал;

6.5.3. Бүртгэлийн ба тайлагналын валют;

6.5.4. Санхүүгийн тайлангийн зүйл тус бүрээр хүлээн зөвшөөрөх зарчим, үнэлж бүртгэх арга;

6.5.5. Бүх төрлийн нөөц, сан байгуулах арга;

6.5.6. Бодит үнэ цэнийн үнэлгээ, тооцоолол;

6.5.7. Болзошгүй зүйлс;

6.5.8. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга;

6.5.9. Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх зарчим.

6.6. Тайлант хугацааны төгсгөлд гадаад валютаар илэрхийлэгдсэн зүйлсийг төгрөгт (бүртгэлийн валют) хөрвүүлэхэд ашигласан, Монголбанкнаас зарласан гадаад валютын албан ханшийг тодруулж болно. Энэ мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн тодруулгын аль тохиромжтой гэж үзсэн хэсэгт дурдана.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

6.7. Энэ хэсэгт нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа, тооцооллыг өөрчлөлтийн талаар НББОУС 8-д заасны дагуу тодруулна.

6.8. Хэрэв компани нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн бол өөрчлөх болсон шалтгаан, өөрчлөлтийн шинж чанар, шилжилтийн нөхцлийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлого илүү найдвартай, хамааралтай мэдээллээр хангана гэж үзсэн шалтгаан, түүний санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөөлөл зэргийг тодруулна.

6.9. НББОУС 8-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг гүйцээн мөрдөх горимоор хүлээн зөвшөөрч байгаа бол түүний шинж чанар, санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөө, ирээдүйд үзүүлж болзошгүй нөлөөлөл зэргийг тодорхойлох боломжтой үед тодруулна.

6.10. Компани өмнөх тайлант хугацаанд хамаарах алдааг илрүүлж, залруулсан бол энэ талаар тодруулна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

6.11. НББОУС 7-д заасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн шалгуур хангасан хөрөнгө, түүний тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлт, бусад шаардлагатай нэмэлт тайлбарыг тодруулна. Компанийн үйл ажиллагааны цар хүрээг өсгөх, тогтвортой байдлыг хангах зорилгоор гарсан мөнгөн гүйлгээг тусгайлан тодруулж болно.

Даатгалын авлага

6.12. Даатгалын авлагын ангилал тус бүрээр тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тодруулахаас гадна дараах зүйлсийг тодруулна.

6.12.1. Даатгалын авлагын барагдуулах хугацаараар ангилан харуулах;

6.12.2. Даатгалын авлагын найдваргүй гэж даснаас хассан дүн;

6.12.3. Холбоотой талаас авах даатгалын авлага;

6.12.4. Өмнөх тайлант хугацаанд сангаар хаасан даатгалын авлагын тайлант хугацаанд барагдуулсан дүн;

6.12.5. Бусад шаардлагатай нэмэлт тайлбарыг тодруулна.

Даатгалын хөрөнгө

6.13. Даатгалын хөрөнгийн ангилал тус бүрээр тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг, тайлбарын хамт тодруулна. Даатгалын хөрөнгийг тооцоолсон аргыг тодруулна. Бусад шаардлагтай нэмэлт тайлбарыг тодруулна.

Хөрөнгө оруулалт

6.14. Хадгаламж, хадгаламжийн сертификат: Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хувьд дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгана.

- 6.14.1. Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын бүрэлдэхүүн, ангилал;
- 6.14.2. Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын бодит үнэ цэн болон хорогдуулсан өртөг;
- 6.14.3. Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хүү буюу бусад өгөөж;
- 6.14.4. Даатгалын компанийн эзэмшилд байгаа боловч компани өөрөө ашиглах боломжгүй, хязгаарлагдмал хадгаламж, хадгаламжийн сертификат;
- 6.14.5. Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарын хамт тодруулна.
- 6.14.6. СТОУС 7-д заасан бусад тодруулгад холбогдох үнэлгээний аргачлалыг ашиглан тооцсон дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын үнэ цэн бууралтыг тодруулна. Үнэлгээний аргачлалаар үнэ цэнийн бууралтыг тогтоох боломжгүй тохиолдолд хөрөнгийн чанарын талаар тодруулж, тайлбарлаж болно.

6.15. Үнэт цаас:

- 6.15.1. Даатгалын компани үнэт цаасны ангиллыг тодорхойлсон үндэслэлээ баримтжуулж, баталгаажуулах бөгөөд ангилал тус бүрээр санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэнэ.
 - 6.15.2. Үнэт цаасны ангилал бүрээр эргэн төлөгдөх хугацааг тодруулна. СТОУС 7-д шаардсан бусад тодруулгууд болон хөрөнгө оруулалтын үнэт цаасны чанарын талаарх тодруулга, дараах ангилал бүрээр хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй үнэт цаасыг тодруулна: арилжааны үнэт цаас, хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас.
 - 6.15.3. Даатгалын компани хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй гэж ангилсан өрийн үнэт цаасны хөрөнгийн чанарын талаар дэлгэрэнгүй мэдээллийг тодруулна.
 - 6.15.4. Үнэт цаасны бодит үнэ цэнийг үнэлэн, тооцсон аргачлалыг тодруулна. Үнэт цаасны арилжаатай холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, шинжилгээний талаар тодруулна.
- 6.16. Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт:
- 6.16.1. Хараат ба хамтын хяналттай аж ахуйн нэгж, охин компанийн саналын эрхтэй энгийн хувьцаанаас компанийн эзэмшилд буй хувь оролцоо, түүнд гарсан өөрчлөлтийг тодруулна.
 - 6.16.2. Санхүүгийн нэгдсэн тайланд хяналтын эрхгүй хувь оролцоо, түүнд гарсан хөдөлгөөнийг мөн тодруулна.
 - 6.16.3. Хараат ба хамтын хяналттай аж ахуйн нэгжид хамаарах охин компанид тогтоосон хяналтыг баримтжуулж, тодруулна.
 - 6.16.4. Хараат ба хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэсэн арга, уг аргатай холбогдуулан хийсэн үнэлгээ, тооцооллын нэмэлт тодруулгыг хийнэ.
 - 6.16.5. Хараат ба хамтын хяналттай аж ахуйн нэгж, охин компанид оруулсан үнэт цаасны эрсдэлийн санд гарсан өөрчлөлтийг хөрөнгө оруулалтын ангилал тус бүрээр тодруулна.

- 6.16.6. Хөрөнгө оруулалтыг бусадтай хийх тооцоонд барьцаа болгосон бол энэ талаар тодруулна
- 6.17. Дериватив санхүүгийн хэрэглүүр:
- 6.17.1. Гадаад валют, үнэт металлыг арилжаалах хэлцэл, бусад деривативыг ангилал бүрээр нь бүлэглэж, холбогдох үлдэгдэл, тайлант хугацаанд гарсан өөрчлөлт, хүлээн зөвшөөрсөн үнэлгээний ба арилжааны орлого, зардлыг тодруулна.
- 6.17.2. Тодруулгад форвард, своп, фьючерс, опшин хэлцэл, бусад деривативтай холбоотойгоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн деривативын бодит үнэ цэнийн тооцоолол, түүнд ашигласан үнэлгээний аргыг оруулна.
- 6.17.3. Гадаад валют, үнэт металл, үнэт цаасыг худалдах эсвэл худалдан авахаар байгуулсан форвард, своп, фьючерс, опшин хэлцэлтэй холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, түүнд даатгалын компанийн зүгээс хийсэн үнэлгээ, шинжилгээг тодруулна.

Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө

- 6.18. Бусад авлага, урьдчилгаа тооцоотой холбогдуулан дараах тодруулгыг нэмж бэлтгэнэ.
- 6.18.1. Бусад авлагыг барагдуулах хугацаагаар ангилан харуулах;
- 6.18.2. Бусад авлагын авлагын найдваргүй гэж данснаас хассан дүн;
- 6.18.3. Бусад авлага, урьдчилгааг данснаас хасахад үүссэн олз, гарз;
- 6.18.4. Холбоотой талаас авах бусад авлага.
- 6.19. Бараа, материал: Бараа материалтай холбогдуулан хөрөнгийн үнэ цэнийн бууралт, бараа, материалыг данснаас хасахад үүссэн олз, гарзыг нэмж тодруулж болно.
- 6.20. Өмчлөх бусад хөрөнгө: Өмчлөх бусад хөрөнгийг чанар, нэр төрлөөр нь ангилж харуулах ба дараах зүйлсийг тодруулна:
- 6.20.1. Тайлант хугацаанд зээлийн өрөнд авсан санхүүгийн бус хөрөнгийн дүн, холбогдох мэдээлэл;
- 6.20.2. Тайлант хугацаанд нөхөн төлбөрийн тооцоонд авсан санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийн дүн, холбогдох мэдээлэл;
- 6.20.3. Данснаас хассан өмчлөх бусад хөрөнгийн дүн;
- 6.20.4. Тайлант хугацаанд худалдан борлуулсан хөрөнгийн дүн, үүссэн олз ба гарз;

Үндсэн хөрөнгө

- 6.21. Үндсэн хөрөнгийн ангилал тус бүрээр дансны үлдэгдэл, хуримтлагдсан элэгдэл, элэгдлийн зардал, тэдгээрийн тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг хүснэгтийн дагуу харуулах ба дараах мэдээллийг нэмж тодруулна:
- 6.21.1. Ашигласан элэгдлийн арга, элэгдүүлэх хувь хэмжээ;
- 6.21.2. Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотой хөдөлгөөн гарсан бол хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсвэл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээ;
- 6.21.3. Үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн бол үнэлгээ хийгдсэн өдөр, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд гарсан өсөлт, бууралт, ашигласан үнэлгээний аргачлал, эсвэл хөрөнгийн үнэлгээчнээр үнэлүүлсэн үнэлгээ;
- 6.21.4. Санхүүгийн түрээсээр авсан хөрөнгө, холбогдох санхүүгийн түрээсийн өглөг;
- 6.21.5. Барьцаанд байгаа үндсэн хөрөнгө;
- 6.21.6. Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа үндсэн хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүн, бүтэц;
- 6.21.7. Үндсэн хөрөнгийн санхүүжилтэнд бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй үндсэн хөрөнгийн худалдан авалтын урьдчилгаа;
- 6.21.8. Үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарз.

Биет бус хөрөнгө

- 6.22. Биет бус хөрөнгийн ангилал тус бүрээр дансны үлдэгдэл, хуримтлагдсан хорогдол, хорогдлын зардал, тэдгээрийн тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг хүснэгтийн дагуу харуулахын зэрэгцээ дараах мэдээллийг нэмж тодруулна:

- 6.22.1. Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийн хувьд хорогдол тооцоход ашигласан арга, хорогдуулах хугацаа, норм, тайлант жилийн хорогдлын зардлын дүн;
- 6.22.2. Дахин үнэлгээний өөрчлөлтөөс гарсан өртгийн өсөлт, бууралт ба өмч, орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралт;
- 6.22.3. Биет бус хөрөнгийн үнэ цэнийг бууруулахтай холбоотойгоор хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсвэл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээ;
- 6.22.4. Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа биет бус хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүн, бүтэц;
- 6.22.5. Биет бус хөрөнгийн санхүүжилтэнд бүртгэсэн, харахан хүлээн аваагүй биет бус хөрөнгийн худалдан авалт;
- 6.22.6. Биет бус хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарз.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

6.23. НББОУС 40-д заасны дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд ашигласан хэмжилтийн суурь, бодит үнэ цэнийн загвар ашигладаг бол бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга, бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн олз, гарз, хэрэв түрээсэлдэг бол түрээсийн орлого, түрээсэлсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зардал, хэрэв өртгийн загвар ашигладаг бол хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцох арга болон бусад тодруулгыг хийнэ.

Даатгалын өглөг

6.24. Даатгалын өглөгийг нэр төрлөөр нь ангилж, тайлант үеийн эхний ба эцсийн үлдэгдэлийг харуулах ба бусад нэмэлт тайлбар тэмдэглэлийг тодруулна. Дансны өглөгийн төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн гэж ангилсан дүнг тодруулна. Шаардлагатай тохиолдолд материаллаг дүнтэй даатгалын өглөгийг тусд нь тодруулж болно.

Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр

6.25. Бусад өр төлбөрт багтсан бусдад өгөх өглөг, салбар хоорондын өглөг, бусад өглөг, татвар, НДШ-ийн өглөг (дутуу төлөлт), ажилтан албан хаагчидтай үүссэн тооцоо гэх мэт өр төлбөрийг өмнөх тайлант үеийн үлдэгдэлтэй харьцуулан тодруулна.

6.26. Ногдол ашгийг тайлагналын өдрөөс санхүүгийн тайланг албан ёсоор баталгаажуулж гаргах өдрийг хүртэлх хугацаанд зарласан ногдол ашгийг санхүүгийн тайланд дараа үеийн үйл явдлаар тодруулна.

6.27. Ажилтнуудад олгох тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хөгжлийн сантай холбоотойгоор дараах зүйлсийг тодруулна:

- 6.27.1. Тэтгэвэр, тэтгэмжийн төрлүүд, тэдгээртэй холбогдон гарсан зардал;
- 6.27.2. Урт хугацаат тэтгэвэр, тэтгэмжийн актуар тооцоолол, холбогдох орлого, зардал;
- 6.27.3. Удирдах албан тушаалтнуудад олгохоор тооцоолсон нийт тэтгэвэр, тэтгэмжийн дүн;
- 6.27.4. Ажилтнуудад хувьцаагаар олгосон шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж ба хувьцаанд суурилсан төлбөрийн нөхцөл.

Хоёрдогч өглөг

6.28. Хоёрдогч өглөгийг бүрдүүлж буй хэрэгслүүдийг дурдаж, тэдгээрийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарлан тодруулна.

Эзэмшигчдийн өмч

6.29. Хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлж буй хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хувьцаанд хамааралтай эрх, давуу эрх, эрхийн хязгаарлалт болон тайлант хугацаанд нэмж гаргасан хувьцааны тоо, үүссэн нэмж төлөгдсөн капитал, нэмж төлөгдсөн капиталд гарсан бусад өөрчлөлт, халаасны хувьцаанд гарсан өөрчлөлт, гаргасан хувьцааны опцион зэргийг тодруулна. Өөрийн хөрөнгөнд багтсан сангууд, тэдгээрийн зориулалтыг тодруулна.

6.30. Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн өмчийн ажил гүйлгээ. Тухайлбал, нэмж гаргасан хувьцаа, хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашиг гэх мэт.

6.31. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын улмаас хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд гарсан залруулгын дүнг тодруулж, дэлгэрэнгүй тайлбар хийнэ. Мөн холбогдох стандартанд шаардсаны дагуу өөрийн хөрөнгөөр шууд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал, олз, гарзын дүнг зүйл тус бүрийн болон нийт дүнгийн хувьд тодруулна.

Даатгалын орлого ба зардал

6.32. Тайлант хугацааны орлого, зардлыг тодорзуулахдаа:

6.32.1. Орлого хүлээн зөвшөөрөхөд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна.

6.32.2. Орлогын нэр төрөл бүрээр хүлээн зөвшөөрсөн дүнг тодруулна.

6.32.3. Даатгалын орлогын гол нэр төрлийн талаар тодруулна.

6.32.4. Зардал хүлээн зөвшөөрөхөд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна. Зардлын нэр төрөл бүрээр хүлээн зөвшөөрсөн дүнг тодруулна.

6.32.5. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, албан татвар, төлбөр, хураамж, томилолт, бичиг хэрэг, шуудан холбоо, мэргэжлийн үйлчилгээ, сургалт, сонин сэтгүүл захиалга, даатгал, цахилгаан, ус, дулаан, засвар, элэгдэл хорогдол, түрээс, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ, тээвэр, шатахуун, хүлээн авалт, зар сурталчилгааны зардал зэргийг борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын гэж ангилж тайлант оны болон өмнөх оны дүнг тодруулна.

Орлогын албан татварын зардал

6.33. Тайлант орлогын татварын зардалтай холбогдуулан дараах нэмэлт тодруулгыг бэлтгэнэ:

6.33.1. Татвар ногдох орлогын дүн, тооцоолсон ба бодит татварын зардлын хооронд хийгдэх тохируулга;

6.33.2. Ногдуулсан татварын зардлын дүн;

6.33.3. Татварын тооцоогоорх авлага, өглөгийн тайлант үеийн өөрчлөлт, үлдэгдэл;

6.33.4. Хойшлогдсон татварын хөрөнгө, хойшлогдсон татварын өглөгийн дүн, эдгээрт тайлант үед гарсан өөрчлөлт, түр зөрүүг үүсгэсэн тэнцлийн дансдын үлдэгдэл.

Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр

6.34. НББОУС 37-ын дагуу тайлагналын өдрийн байдлаар хэрэгжих магадлалтай болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн шинж чанар, боломжтой бол тэдгээрийн үр нөлөөллийг харуулсан тооцооллыг тодруулна.

Тайлагналын үеийн дараах үйл явдал

6.35. НББОУС 10-ын дагуу тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал бүрээр эдгээрийн онцлог шинж, санхүүгийн үр нөлөөг тодруулна. Тухайлбал, санхүүгийн тайлагналын өдөр, санхүүгийн тайланг хэвлэн нийтлэх хугацааны хооронд гарсан дараах зүйлсийг тодруулна:

6.35.1. Даатгалын компанийн үйл ажиллагаа, зохион байгуулалтанд гарсан томоохон өөрчлөлт;

6.35.2. Нөлөө бүхий үйл явдал (НББОУС 10-д заасан залруулах ба үл залруулах үйл явдал) болон нягтлан бодох бүртгэлийн зааварт багтсан дараа үеийн үйл явдлаас үүссэн олз ба гарз.

Тэнцлийн гадуурх данс

6.36. Тайлант хугацаанд тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн зүйлсийн үлдэгдэл, түүнд гарсан өөрчлөлтийг тодруулна. Зэрэгцүүлэх зорилгоор өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна.

